



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/192

Номгон

Аймгийн Засаг даргын нэрэмжит аймгийн аварга шалгаруулах цэрэг-спортын “Дөл-2023” цогцолбор тэмцээн зохион байгуулж явуулах тухай

Монгол Улсын “Биеийн тамир спортын тухай хууль”-ийн 8 дугаар зүйлийн 8.1.1, Батлан хамгаалахын сайдын Баянхонгор аймгийн Засаг даргатай 2023 онд хамтран ажиллах гэрээний 03 дугаар зүйлийн 1.7, дахь хэсэг, Засгийн газрын 2016 оны 215 дугаар тогтоолоор баталсан “Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний тоо бүртгэл хөтлөх, мөнгөн төлбөрийг төлөх, хураан авах, төлбөрийн орлогыг ашиглах” журмын 4 дүгээр зүйлийн 4.1.9 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын нэрэмжит аймгийн аварга шалгаруулах цэрэг-спортын “Дөл-2023” цогцолбор тэмцээнийг 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр зохион байгуулсугай.


2.Аймгийн Засаг даргын нэрэмжит аймгийн аварга шалгаруулах цэрэг-спортын “Дөл-2023” цогцолбор тэмцээнд удирдамжийн дагуу бэлтгэлийг хангаж, бүрэн хамрагдахыг сумдын Засаг дарга нар болон ерөнхий боловсролын сургуулиудын захирал нарт үүрэг болгосугай.

3.Цэрэг-спортын “Дөл-2023” цогцолбор тэмцээний шаардагдах зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

4.Тэмцээнд шаардагдах 4,758,460 (Дөрвөн сая долоон зуун тавин найман мянга дөрвөн зуун жар) төгрөгийг Цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрийн орлогын орон нутагт үлдэх хэсгээс зарцуулахыг Цэргийн штаб (хурандаа Г.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Батсуурь)-д үүрэг болгосугай.


ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

040310481

125
Аймгийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 1199 дугаар захирамжийн хэвсрэлт



ЗАРДЛЫН ТООЦОО

№	Албан тушаал	Зардлын тооцоо		
		Тоо	Нэг бүрийн дүн	Нийт дүн
1	Хоолны зардал	300	5000 төг	1.500.000 төг
2	Шатахууны зардал	19	682л*2530	1,725,460 төг
3	Хулдаасан хэвлэл	1	24м ² х12000	288.000 төг
4	Цэрэг-спортын "Дөл-2023" цогцолбор тэмцээн		I байр-1 Өргөмжлөл II байр-1 Өргөмжлөл III байр-1 Өргөмжлөл Медаль Нийт	200.000 40.000 150.000 40.000 100.00 40.000 45х15.000=675.000 1,245,000
Нийт				4,758,460 төг

оОо